**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/160/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням<br>Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

*1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....3*

*2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....5*

*2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5*

*2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6*

*2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8*

*2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....10*

*2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....10*

*3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....12*

*3.1 Төлбөрийн акт....12*

*3.2 Зөвлөмж....13*

*4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....14*

*5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ....15*

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.23 № 112

танай ____________-ны №____________-т

МЯНГАД СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ЭМЧ Ж.ЭНХЧУЛУУН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Онцлох асуудал нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 55.9 сая төгрөг, үүний 4.6 сая төгрөг нь он дамжсан үлдэгдэл байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8426050206
А4-төөт-2026

Тайлант онд урсгал төсвөөс 3.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон хандив тусламжаар 70.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

**Бусад асуудал**

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хөтөлбөр, 8 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 93.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---:|---:|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,461,238.83** | **130,258,429.97** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 6,241,568.29 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 6,241,568.29 |
| **3121** | **Төгрөг** | - | 6,241,568.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 6,241,568.29 |
| **33** | **АВЛАГА** | 73,224,682.85 | 31,262,161.14 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 299,529.70 | 1,639,602.70 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 72,925,153.15 | 29,622,558.44 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 95,236,555.98 | 92,754,700.54 |
| **351** | **Түүхий эд материал** | 61,096,281.53 | 55,962,333.27 |
| 35130 | Эм боох материал | 61,096,281.53 | 55,962,333.27 |
| **354** | **Хангамжийн материал** | 34,140,274.45 | 36,792,367.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,004,300.00 | 877,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,654,974.45 | 31,118,467.27 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 700,000.00 | 1,748,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 396,000.00 | 3,048,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,595,736,555.99** | **2,538,508,567.29** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,595,736,555.99 | 2,538,508,567.29 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,584,884,755.99 | 2,527,776,767.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,225,081,840.00 | 2,237,736,840.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (122,538,115.96) | (177,801,335.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 244,517,252.47 | 263,281,030.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (32,841,641.43) | (53,639,770.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 324,439,630.94 | 332,728,484.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (110,865,909.27) | (125,091,045.93) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 85,930,836.20 | 86,942,356.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,839,136.96) | (36,379,791.96) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,851,800.00 | 10,731,800.00 |
| 39301 | Програм хангамж | 1,725,000.00 | 1,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (855,000.00) | (450,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,981,800.00 | 9,981,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,764,197,794.82** | **2,668,766,997.26** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **17,691,930.21** | **16,339,633.28** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 17,691,930.21 | 16,339,633.28 |
| **413** | **Өглөг** | 17,691,930.21 | 16,339,633.28 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,640,667.43 | 226,879.28 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 8,548,262.78 | 16,112,754.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 4,503,000.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,503,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,746,505,864.61** | **2,652,427,363.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,746,505,864.61 | 2,652,427,363.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 159,985,026.00 | 159,985,026.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,166,953,734.89 | 2,072,875,234.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,166,953,734.89 | 2,166,953,734.89 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (94,078,500.63) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 419,567,103.72 | 419,567,103.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,764,197,794.82** | **2,668,766,997.26** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,285,815,862.08** | **1,496,369,129.63** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,133,482,398.42** | **199,775,336.03** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,127,982,398.42 | 199,775,336.03 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,127,982,398.42 | 199,775,336.03 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 124,041,869.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 2,108,303,211.67 | 70,284,100.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 19,679,186.75 | 5,449,367.03 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,500,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,500,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,152,333,463.66** | **1,296,593,793.60** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 95,336,100.00 | 76,629,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 95,336,100.00 | 76,629,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,056,997,363.66 | 1,219,964,293.60 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,056,997,363.66 | 1,219,964,293.60 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,219,342,242.34** | **1,588,302,793.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,219,342,242.34** | **1,588,302,793.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,203,281,440.13 | 1,466,945,611.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 740,571,797.44 | 934,495,948.22 |
| 210101 | Үндсэн цалин | 349,897,797.44 | 402,405,282.13 |
| 210102 | Нэмэгдэл | 286,934,000.00 | 417,035,967.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 37,026,000.00 | 57,842,125.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 66,714,000.00 | 57,212,573.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,285,000.00 | 115,049,375.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,253,199.03 | 80,288,680.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,136,541.33 | 9,406,875.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,842,561.46 | 5,058,241.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,430,132.33 | 3,984,151.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,622,565.85 | 16,311,425.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 76,396,697.79 | 85,468,122.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,269,683.14 | 6,945,204.39 |
| 210302 | Түлш, халаалт | 59,872,492.65 | 65,166,462.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,254,522.00 | 13,356,456.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36,085,276.75 | 48,414,509.21 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,297,076.75 | 5,006,855.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,808,900.00 | 23,360,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,220,000.00 | 2,359,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,982,200.00 | 3,559,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,776,300.00 | 3,291,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 800.00 | 10,837,104.21 |
| **2105** | **Нормативт зардал** | 110,977,297.71 | 130,075,545.03 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 95,364,947.71 | 107,638,845.03 |
| 210502 | Хоол, хүнс | 15,612,350.00 | 15,686,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 6,750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,764,600.00 | 3,646,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,005,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,252,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,764,600.00 | 1,389,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,450,300.00 | 4,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,450,300.00 | 4,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,707,510.00 | 3,434,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,543,910.00 | 2,553,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 32,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 258,600.00 | 258,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000.00 | 100,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 40,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 135,042,960.44 | 141,491,351.54 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,811,761.00 | 12,806,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 122,231,199.44 | 128,685,251.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,060,802.21 | 121,357,181.61 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 116,383,750.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 70,465,750.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 45,918,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,060,802.21 | 4,973,431.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,060,802.21 | 4,973,431.61 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,066,473,619.74** | **(91,933,663.47)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 285,806.55 | 2,144,837.16 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 285,806.55 | 2,144,837.16 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (285,806.55) | (2,144,837.16) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,066,187,813.19** | **(94,078,500.63)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,096,548,051.51** | **1,463,938,257.31** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,500,000.00** | **124,041,869.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 124,041,869.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 124,041,869.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 124,041,869.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,500,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,500,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,091,048,051.51** | **1,339,896,388.31** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 95,336,100.00 | 76,629,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 95,336,100.00 | 76,629,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 995,711,951.51 | 1,263,266,888.31 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 995,711,951.51 | 1,263,266,888.31 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,111,866,862.13** | **1,457,696,689.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,111,866,862.13** | **1,457,696,689.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,095,806,059.92** | **1,336,339,507.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 734,645,724.20 | 937,598,284.47 |
| 210101 | Үндсэн цалин | 343,971,724.20 | 402,294,402.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 286,934,000.00 | 420,249,183.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 37,026,000.00 | 57,842,125.50 |
| 210104 | Урамшуулал | 66,714,000.00 | 57,212,573.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 92,285,000.00 | 117,700,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,753,800.00 | 79,151,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,382,800.00 | 9,637,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,691,400.00 | 4,818,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,691,400.00 | 4,818,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,765,600.00 | 19,274,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 76,517,197.79 | 69,355,368.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,269,683.14 | 6,945,204.39 |
| 210302 | Түлш, халаалт | 59,992,992.65 | 49,053,708.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,254,522.00 | 13,356,456.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,224,476.75 | 35,956,165.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,437,076.75 | 4,251,855.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,808,900.00 | 23,360,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,220,000.00 | 2,359,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,982,200.00 | 2,693,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,776,300.00 | 3,291,410.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 91,662,688.33 | 124,660,079.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 77,411,328.33 | 98,141,579.55 |
| 210502 | Хоол, хүнс | 14,183,360.00 | 19,768,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 68,000.00 | 6,750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,018,100.00 | 19,552,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 16,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 260,000.00 | 1,252,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,758,100.00 | 2,300,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,450,300.00 | 4,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,450,300.00 | 4,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,836,510.00 | 3,434,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,543,910.00 | 2,553,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 450,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 32,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 258,600.00 | 258,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000.00 | 100,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 129,000.00 | 40,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,166,062.85 | 23,211,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,166,062.85 | 23,211,550.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,060,802.21** | **121,357,181.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 116,383,750.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 70,465,750.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 45,918,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 16,060,802.21 | 4,973,431.61 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,060,802.21 | 4,973,431.61 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(15,318,810.62)** | **6,241,568.29** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (15,318,810.62) | 6,241,568.29 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 6,241,568.29 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **2,166,953,734.89** | 2,746,505,864.61 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (94,078,500.63) | (94,078,500.63) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **2,072,875,234.26** | 2,652,427,363.98 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,477,218,200.00 | 1,452,723,257.41 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,477,218,200.00 | 1,452,723,257.41 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,360,781,900.00 | 1,336,339,507.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 946,509,500.00 | 937,598,284.47 |
| 210101 | Үндсэн цалин | 400,721,000.00 | 402,294,402.13 |
| 210102 | Нэмэгдэл | 422,788,500.00 | 420,249,183.39 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 63,000,000.00 | 57,842,125.50 |
| 210104 | Урамшуулал | 60,000,000.00 | 57,212,573.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,968,000.00 | 117,700,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,333,400.00 | 79,151,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,658,600.00 | 9,637,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,829,300.00 | 4,818,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,829,300.00 | 4,818,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,317,400.00 | 19,274,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 73,354,800.00 | 69,355,368.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,360,000.00 | 6,945,204.39 |
| 210302 | Түлш, халаалт | 50,638,800.00 | 49,053,708.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,356,000.00 | 13,356,456.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,321,200.00 | 35,956,165.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,393,700.00 | 4,251,855.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,360,900.00 | 23,360,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,585,000.00 | 2,359,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,231,300.00 | 2,693,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,750,300.00 | 3,291,410.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 126,631,600.00 | 124,660,079.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,113,100.00 | 97,860,879.55 |
| 210502 | Хоол, хүнс | 19,768,500.00 | 20,049,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,750,000.00 | 6,750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,274,700.00 | 19,552,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,000,000.00 | 16,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,000,000.00 | 1,252,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,274,700.00 | 2,300,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,560,300.00 | 4,870,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,560,300.00 | 4,870,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,966,100.00 | 3,434,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,012,500.00 | 2,553,860.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 32,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 258,600.00 | 258,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 100,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 40,000.00 | 40,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,195,700.00 | 23,211,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,195,700.00 | 23,211,550.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 116,436,300.00 | 116,383,750.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 116,436,300.00 | 116,383,750.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 70,518,300.00 | 70,465,750.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,918,000.00 | 45,918,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,477,218,200.00 | 1,458,964,825.70 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 76,629,500.00 | 71,656,068.39 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 71,656,068.39 | 71,656,068.39 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,278,017,100.00 | 1,263,266,888.31 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,278,017,100.00 | 1,263,266,888.31 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 122,571,600.00 | 124,041,869.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 122,571,600.00 | 124,041,869.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **6,241,568.29** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийг зарим нэр төрлийн хөрөнгө дээр давхар бүртгэсэн нийт 4,164.0 мянган төгрөгийн алдаа[1] зөрчил илэрч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ‘’аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх’’ заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 11,916.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил[2] илэрсэнд 1,864.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 10,052.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,688.7 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

***3.1.1 Илрүүлэлт***: Тайлант онд зарцуулсан эмийг түүвэрлэн анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 499 ширхэг 624.0 мянган төгрөгийн цагийн тариаг илүү зарлагадсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн:*** Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**3.1.2 Илрүүлэлт:** Байгууллагын ажиллагсдад олгосон цалингийн нэмэгдлүүдийг шалгаж үзэхэд байгууллагын нягтлан бодогчид урамшуулалт цалин давхардуулан олгож авлагаар бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн:*** Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**3.2.1. Эдийн засгийн ангилалт, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

***Илрүүлэлт:*** Тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд батлагдсан 1,125.0, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд батлагдсан 1,060.5, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд батлагдсан 1,612.5, бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан 1,247.5 мянган төгрөг нийт 5,045.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр эм боох материал, хоол хүнс, ажилчдад биеийн тамирын хувцас зэрэг зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", хоёрдугаар хавсралт "Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар"-ын Хэрэглүүрийн гуравт: "Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана", Төсвийн захирагчийн үүрэгт: "Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй

***Өгсөн зөвлөмж:*** Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэж, зарцуулалтыг үнэн зөв гаргах

**3.2.2 Худалдан авалт, эмийн тендер оролцогчтой холбоотой асуудал**

***Илрүүлэлт:*** Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг ижил нэр төрөл үнэ бүхий эмийг өөр кодоор бүртгэсэн, тайлант онд 7 нэр төрлийн 20860 ширхэг эм, эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр авч нөөцөлсөн, эмийн захиалга хүргүүлэхдээ судалгаанд үндэслээгүйгээс ЭМГ-т нэр бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг хэрэгцээнээс илүү хүргүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>:*** Эм боох материалын бүртгэлээс тусгай зориулалтын материалыг салгаж бүртгэх, эм эмнэлгийн хэрэгслийг захиалгыг судалгаанд үндэслэн хийх, хэрэгцээнээс илүү нөөцлөхгүй байх, хугацаа дууссан эм, тариаг акталж устгах ажил зохион байгуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг  хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг  Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

***4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*** */мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийг зарим нэр төрлийн хөрөнгө дээр давхар бүртгэсэн | 1 | 4,164.0 | | | 1 | 4,164.0 | 1 | 4,164.0 | | |
| **Нийт дүн** | **1** | **4,164.0** | | | **1** | **4,164.0** | **1** | **4,164.0** | | |

### *4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн | 1 | 5,045.6 | | | | | 1 | 5,045.6 |
| Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг ижил нэр төрөл үнэ бүхий эмийг өөр кодоор бүртгэсэн, тайлант онд 7 нэр төрлийн 20860 ширхэг эм, эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр авч нөөцөлсөн, /50 хувиар тооцов/ | 1 | 5,007.2 | | | | | 1 | 5,007.2 |
| Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 499 ширхэг цагийн тариаг илүү зарлагадсан | 1 | 624.0 | 1 | 624.0 | | | | |
| Байгууллагын ажиллагсдад олгосон цалингийн нэмэгдлүүдийг шалгаж үзэхэд байгууллагын нягтлан бодогчид урамшуулалт цалин давхардуулан олгож авлагаар бүртгээгүй | 1 | 1,240.0 | 1 | 1,240.0 | | | | |
| **Дүн** | **4** | **11,916.8** | **2** | **2,020.0** | **0** | - | **2** | **10,052.8** |

## 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо: Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр: Санал дүгнэлт гаргасан | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр: Түүвэрт хамруулсан | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр: Аудит хийгээгүй | Санал дүгнэлтийн хэлбэр: Зөрчилгүй | Санал дүгнэлтийн хэлбэр: Хязгаарлалттай | Санал дүгнэлтийн хэлбэр: Сөрөг | Санал дүгнэлтийн хэлбэр: Дүгнэлт гаргахаас татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |